

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:**

“3.1.10.”нэгж талбарын хувийн хэрэг” гэж газар өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхтэй холбоотой цаасан болон цахим баримт бичгийн бүрдлийг;”

**2/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:**

“4.1.7.Газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын салшгүй хэсэг байна.”

**3/5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“5.4.Газар өмчлөгч нь газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулна.”

**5/23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 23 дахь заалт:**

“23.2.23.нэгж талбарын хувийн хэрэг хөтлөх журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.”

**4/34 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг:**

“34.12.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал дараахь тохиолдолд холбогдох мэдээллийг газрын мэдээллийн үндэсний системд тухай бүр оруулна.

34.12.1.газар эзэмших эрх олгосон, хугацааг сунгасан, бусдад шилжүүлсэн;

34.12.2.газар эзэмших эрх дуусгавар болсон.”

**5/ 44 дүгээр зүйлийн 13 дахь хэсэг:**

“44.13.Аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумын газрын даамал дараахь тохиолдолд холбогдох мэдээллийг газрын мэдээллийн үндэсний системд тухай бүр оруулна:

44.13.1.газар ашиглах эрх олгосон, хугацааг сунгасан;

44.13.2.газар ашиглах эрх дуусгавар болсон.”

**2 дугаар зүйл.**Газрын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь заалтын “байршил” гэсний дараа “нэгж талбарын дугаар,”, 34 дүгээр зүйлийн 34.6.3, 44<sup>1</sup> дүгээр зүйлийн 44<sup>1</sup>.6.3 дахь заалтын “зураг” гэсний дараа “,нэгж талбарын дугаар” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.6 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“35.3.6.энэ хуульд заасны дагуу газрын эрхээ барьцаалах, шилжүүлэх тохиолдолд газрын улсын бүртгэл болон энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх;”

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ, ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Кадастрын зураглал, газрын кадастрын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

#### **1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт:**

“3.1.16.”нэгж талбарын дугаар” (плот) гэж газар өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг газрын улсын бүртгэлд бүртгэснийг нотолж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон дахин давтагдахгүй дугаарыг;”

#### **2/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 17 дахь заалт:**

“3.1.17.”дэд талбар” гэж хилээр хязгаарлагдсан, газар ашиглалтын зориулалт нь ялгаатай газрын улсын бүртгэлийн нэгжийг.”

#### **3/16 дугаар зүйлийн 15 дахь хэсэг:**

“16.15.Нэгж талбар дугаарлах журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.**Кадастрын зураглал, газрын кадастрын тухай хуулийн дараахь заалтыг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

#### **1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:**

“3.1.4.”нэгж талбар” (парсел) гэж тодорхой хилээр хязгаарлагдсан, дахин давтагдахгүй дугаартай, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид олгосон газрыг;”

#### **2/16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“16.2.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулах бөгөөд Үндэсний дата төвд үүссэн газрын кадастрын мэдээллийн сан болон улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн мэдээллээс бүрдэх Дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл солилцох боломжтой байна.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 29.10 хэсэг нэмсүгэй:

“29.10.Иргэний өмчийн газрыг эзэмших, ашиглах, түр ашиглах эрх эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр баталгаажна.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээний” гэснийг “эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “шийдвэрийг” гэснийг “шийдвэр болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон нэгж талбарын дугаарыг”, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “бүртгэх” гэснийг “бүртгэж газрын мэдээллийн санд оруулах”, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд” гэснийг “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд”, 24.2 дэх хэсгийн “бүртгэлд тусгах” гэснийг “бүртгэж газрын мэдээллийн санд оруулах”, 27 дугаар зүйлийн 27.2.3 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсгийн “үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд” гэснийг “эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4.6, 4.7 хэсэг нэмсүгэй:

**1/4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“4.6.Нотариатч нь үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс улсын бүртгэлийн байгууллагатай эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим сангаас мэдээлэл авах гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.”

**2/4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**

“4.7.Нотариатч нь энэ хуулийн 4.6-д заасны дагуу авсан мэдээллээ өмчлөгч болон бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар ашиглах, бусдад ашиглуулахыг хориглоно.”

**2 дугаар.**Нотариатын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлийн тухай” гэснийг “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ИРГЭНИЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Иргэний хуулийн 42<sup>1</sup> дүгээр зүйлийн 42<sup>1.1</sup> дэх заалтын “Хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлээс бусад хуульд бичгээр хийхээр заасан” гэснийг “Хуульд зааснаар бүртгүүлэх, нотариатаар гэрчлүүлбэл зохих болон бичгээр хийхээр заасан” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

**1/26 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:**

“26.10.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.”

**2/27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:**

“27.1.14.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газар эзэмших, ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байх;”

**3/49 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг:**

“49.12.Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсан этгээдийн газар эзэмших, ашиглах эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “барьцаалуулагч болон улсын бүртгэлийн байгууллагаас” гэснийг “барьцаалуулагчаас” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “улсын бүртгэлийн байгууллага хууль зөрчсөний улмаас” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 16.2, 17.2, 17.3, 18.7, 19.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлийн тухай” гэснийг “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.Гудамж, зам, талбайд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал үл хөдлөх эд хөрөнгийн байршлын хаяг олгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2016 он ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг